

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛЖ
БАЙГААТАЙ ХОЛБООТОЙ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН
БАЙР СУУРЬ**

2025 оны төсвийн тодотголыг хэлэлцэн батлахтай холбоотой Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд удаа дараа өөрчлөлт оруулж байгаад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл харамсаж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2025 оны 06 сарын 25-ны өдөр хийсэн нэмэлт, 2025 оны 07 сарын 03-нд нэн яаралтай горимоор өргөн барьсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь дараах үр дагаврыг үүсгэж байна. Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-д **“харгалзах тухайн”** гэсэн үг нэмснээр 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг өөрчлөх, 7.6-д **“болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор”** гэсэн үг нэмснээр Дунд хугацааны төсвийн хүрээ мэдэгдэл батлагдсаны дараа болон Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-д заасан хязгаарлалтыг баримтлахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Засгийн газраас 2025 оны 07 сарын 03-ны өдөр яаралтай хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлагыг бууруулах тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-д заасан хязгаарлалтыг баримтлахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Төсвийн тогтвортой байдлын 7.5-д “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш гурваас доошгүй сарын хугацаанд харгалзах тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглоно” хэмээн заасан нь төсвийн бодлогын тогтвортой байдлыг хадгалах, төсвийн орлогын төлөвлөлтийг бодитой хийж төсвийн орлогод нийцсэн зарлага төлөвлөх, төсвийн сахилга батыг сайжруулах онцгой ач холбогдол бүхий заалт юм. Гэтэл дээрх өөрчлөлтүүд орсноор төсвийн орлого ямар нэг хэмжээгээр буурсан тохиолдолд төсвийг тодотгож Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж болох нэмэлтийг оруулж байна.

Иймд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд удаа дараа өөрчлөлт оруулж төсвийн тогтвортой байдал, сахилга бат, хяналтыг алдагдуулах нөхцөл бүрдүүлж байгааг онцгой анхаарах шаардлагатай гэсэн байр суурьтай байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл үүсээд байгаа нөхцөл байдал нь хууль зүйн тодорхой хязгаарлалтад орсон, 2026 оны төсвийг төлөвлөх, өргөн барих, батлахтай холбоотой хүндрэлтэй байдлыг үүсгэж байгааг ойлгож байгаагаа илэрхийлье.

Иймд цаашид төсвийн эрх зүйн орчныг дордуулсан, тогтвортой байдлыг алдагдуулсан хуулийн нэмэлт өөрчлөлтийг хийхгүй байх нь зүйтэй юм. Мөн Засгийн газраас 2025 оны 07 сарын 03-ны өдөр яаралтай хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн

мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан төсвийн орлого, зарлага буурах ерөнхий нөхцөлийг илүү тодорхой болгосон байдлаар болон тухайн нэмэлтийг нэг удаагийн шинжтэй буюу тодорхой хугацааны хязгаарлалттайгаар өөрчлөн найруулах шаардлагатай гэж үзэж байна. Ингэснээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зарчмын томоохон ухралт хийхээс сэргийлэх боломжтой юм.